



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.17 № 2/03 ЧАГ-САГ/2014/НО/СТА-ТМЗ

Төлбөрийн акт тогтоох тухай

ЭМШУИС-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийх явцад албан томилолтын мөнгө илүү олгосон зөрчил илэрлээ.

Улаанбаатар хотод томилолтоор ажилласан 7 ажилтанд нийт 382.5 мянган төгрөг, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Завхан аймгуудад ажилласан 8 ажилтанд нийт 980.0 мянган төгрөгийг тус тус илүү олгосон байна. /тооцоо хавсралт № 3/

Энэ нь “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 2 дахь заалт “Төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгох” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэсэн заалт, мөн Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47-р тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Дээрх хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, томилолтын мөнгө илүү олгосон 1,362.5 мянган төгрөгийг хавсралт № 3-д заасан ажилтануудаас суутган авч Үндэсний аудитын газрын төрийн сан банкны 900000601 тоот дансанд 2014 оны 06 дүгээр сарын 10-ний дотор төвлөрүүлж, хариуг албан ёсоор 2014 оны 06-р сарын 30-ны дотор УАГ-ын Санхүүгийн аудитын газарт ирүүлэхийг ЭМШУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн захирал Д.Зоригтбаатар, ерөнхий нягтлан бодогч Х.Сарантуяа нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
ШИНЖЭЭЧ
Н.НЯМДАВАА

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМШУИС-ийн ЗАХИРАЛ
Г.БАТБААТАР

СЭЗГ-ЫН ДАРГА
Р.ДАШЖАВ